



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 374

Улаанбаатар хот

Ачаа, зорчигч тээвэрлэлтийн жишиг тариф
батлах тухай

Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Ачаа тээвэрлэлтийн 1 тн.км-ийн жишиг тарифыг 1 дүгээр хавсралтаар, зорчигч тээвэрлэлтийн 1 хүн.км-ийн жишиг тарифыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү жишиг тарифыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөсүгэй.

3. Ачаа, зорчигч тээвэрлэлтийн жишиг тарифыг баталсантай холбогдуулан "Автотээврийн жишиг тариф шинэчлэн батлах тухай" Зам, тээврийн сайдын 2013 оны 162 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН

081109

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны
12 дугаар сарын 13 ны өдрийн 374 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТИЙН 1 ХҮН.КМ-ИЙН ЖИШИГ ТАРИФ


№	Үзүүлэлт	Жишиг тариф /Төгрөг/
1	1 хүн.км-ийн жишиг тариф	60-75

Тайлбар:

1. Нэг зорчигч 20 кг хүртэл тээшийг үнэгүй авч явж болно.
2. Асран хамгаалагчтай яваа 0-5 хүртэл насны хүүхэд үнэгүй зорчино. /Хэрэв суудал эзлэх бол уг тайлбарын 4-т заасны дагуу 50%-ийн хөнгөлөлттэй үнээр зорчино./
3. 6-12 насны хүүхэд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр зорчино.
4. Хүн.км-ийн жишиг тарифыг тээврийн хэрэгслийн төрлөөс хамааруулан үйлчилгээний гэрээнд тусгана.

---000---

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны
12 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН 1 ТН.КМ-ИЙН ЖИШИГ ТАРИФ

/Төгрөг, мөнгө/

№	Тээвэрлэлтийн зай, км	Ачааны зэрэг		
		I	II	III
1	1	960.47	1272.78	1699.11
2	2	621.48	838.56	1074.01
3	3	516.48	691.21	925.58
4	4	478.40	635.53	851.36
5	5	453.71	583.93	785.90
6	6	415.61	546.18	732.15
7	7	376.64	495.86	663.48
8	8	373.4	492.65	656.86
9	9	366.48	486.25	648.33
10	10	348.90	461.13	619.12
11	11-15	334.65	444.24	591.18
12	16-20	323.62	429.95	571.79
13	21-25	314.10	415.02	553.86
14	26-30	296.55	392.84	524.64
15	31-40	281.83	375.49	497.34
16	41-50	271.67	358.94	477.72
17	51-60	261.49	346.55	460.03
18	61-70	251.10	331.84	440.61
19	71-80	240.70	317.77	422.27
20	81-90	229.88	304.34	403.91
21	91-100	219.71	290.47	395.19
22	100-гаас дээш	216.56	280.66	391.34

Тайлбар:

1. Нэгдүгээр зэрэглэлийн ачаа нь: 2,3-р зэрэглэлд хамрагдаагүй ачааг;
2. Хоёрдугаар зэрэглэлийн ачаанд: Үйлдвэрийн бараа (Төрөл бүрийн бараа, гадуур дотуур бэлэн хувцас, гутал, даавуун эдлэл, гэр ахуйн болон албан ажлын хэрэгцээний цахилгаан хэрэгсэл, барилгын материал, хөдөө аж ахуйн хүнсний бараа гэх мэт);
3. Гуравдугаар зэрэглэлийн ачаанд: Нийтлэг ачаа (Барилгын дулаалгын шилэн хөвөн, хөөсөнцөр материал, хийцүүд, мебель гэрийн эд хогшил, тооно, өндөг, архи пиво, ундааны хоосон шил, ноос ноолуур, сүрэл, өвс) Тусгай ачаа (уурын тогоо, бойлер, бункер, циклон, төрөл бүрийн яндан хоолой, бог бод мал, гахай шувуу, бороожуулагч).